

Living the Lotus 4

Buddhism in Everyday Life

2024

VOL. 223



Rissho Kosei-kai of
Bangladesh

Living the Lotus Vol.223 (2024.04)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Б.Мөнхцэцэг, Т.Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami
-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг тууцгааяа гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Байгаагаар нь хүлээн авах тухай

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

“Үнэн” гэж юуг хэлэх вэ?

“Хадны завсраар ургасан нахиа нь хавар цаг ирснийг сануулна”. Хадны завсраар урсах хүрхрээний хүчтэй урсгалын ирмэгт нахиагаа гаргасан ойм (ургамал)-ыг харсан Шикино хунгайж (Тэнжи хааны 7 дахь хүү)-ийн зохиосон хавар цагийг айлчлан ирсэнд баярласан утгатай шүлэг юм.

Энэхүү шүлэг нь Нарагийн он тоолол (710–794 он)-ын үед бичигдсэн “түмэн навчны цоморлиг”-ийн нэг мөрт боловч орчин цагийн бидэнд ч “урин хавар ирлээ дээ” гэсэн сэтгэл догдлуулсан мэдрэмжийг өгөх Японы гайхалтай шүлэг юм.

Дээрх шүлэгт гардаг шиг гярхай нүдээр байгаль эхээ хайрлаж, аливаа зүйлийн бодит төрх байдлыг талархал, баяр хөөртэй хүлээн авах нь өнөөгийн бидэнд хялбар чадах зүйл биш юм. Иймэрхүү дуу шүлэг нь бидний дотоод сэтгэлийн хар бараан, дутагдалыг сануулж байдаг.

Хуучны сударт Шагжамүни багш болон Бярман лам хоёрын хооронд өрнөх харилцан яриа тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Тэр харилцан яриа дотор “үнэнийг дагаж мөрдөнө гэдэг миний доторх хадуур юм” гэсэн үг байдаг. Шагжамүни багшийн хувьд “үнэнийг дагаж мөрдөх” нь тариан талбайг боловсруулах хүний хувьд хадууртай ижил гэсэн үг юм. Тэгвэл энд дурдагдаж байгаа “үнэн” гэж юуг хэлж байна вэ?

“Үнэн” гэдэг үгийг сонсоод хамгийн түрүүнд “үнэн ном” гэдэг үг санаанд бууж байна. Бурханы сургаал нь хүн бүрийг үнэн номыг ойлгож гэгээрэхүүлэхийн төлөө зорьдог тул “үнэн номыг дагаж мөрдөнө” гэдэг нь үнэн номын дагуу амьдарна гэж ойлгож болно. Гэхдээ буддын сударт дурдагдах “үнэн ном” гэдгийг “аливаа зүйлсийн байгаа байдал” “бодит төрх байдал” гэж тайлбарладаг. Энэ утгаар нь аваад үзвэл аливаа зүйлийн “бодит төрх байдал”-ыг дуртай дургүй гэсэн сэтгэл хөдлөлтэй холихгүйгээр харж, тэр “байгаа байдал”-ыг хүлээн авах нь “үнэн номыг дагаж байгаа” явдал бөгөөд түүнд саад болдог сэтгэлийн гэм гэсэн зэрлэг, хортой өвсийг сэтгэлдээ газар авхуулахгүй байхаар Шагжамүни багш ч хичээж байжээ гэдгийг эндээс ажиглан мэдэж болно.

Зэрлэг гэдэг нэртэй өвс байхгүй

“Сэтгэлийн гэм нь бодь сэтгэлтэй ижил” гэсэн үг байдаг ба нисваанис буюу сэтгэлийн гэм нь хөгжил дэвшлийн эх үндэс ч болох тохиолдол байдаг. Өөрөөр хэлбэл сэтгэлийн гэм, бодь сэтгэл нь эцсийн дүндээ нэг зүйл гэж хэлж болно. Хүн төрөлхтөн сэтгэлийн гэм ихтэй амьтан учраас л үнэн номыг ойлгож ухаарах хүчийг тээдэг гэвэл сэтгэлийн гэм нь биднийг тэтгэж, хөгжүүлдэг талархалтай зүйл бас мөн юм. Тэгэхээр сэтгэлийн гэм нь том байх тусмаа тэр хүн томоохон өөрчлөлтийг гаргаж болох юм. Шагжамүни бурхан “сэтгэлийн хадуур” гэж хэлсэн нь жаахан болгоомж алдахад л битүү ургах сэтгэлийн гэм хэмээх зэрлэг өвсийг сэтгэлдээ хэтэрхий газар авхуулахгүй байхаар байнга тайрч, тухай бүрт нь тайрсан өвсөө сэтгэлийн хөрсөндөө жигд тараан тавьбал, тэр нь эргээд сэтгэлийн талбайг томсгох билиг оюуныг төрүүлэх шим тэжээл болж, илүү үр шимтэй зөөлөн талбайг бий болгодог учраас юм.

Зэрлэг өвс гэснээс ургамал судлалын эрдэмтэн Макино Томитаро (1862–1957он) нь “зэрлэг өвс” гэж хэлсэн нэгэн сэтгүүлчид хандан “хорвоо дээр зэрлэг гэдэг өвс байдаггүй. Ямарч өвс байлаа өөрийн гэсэн нэртэй байдаг” гэж анхааруулан хэлсэн яриа нь их алдартай. Үүнтэй ижил сэтгэлийн гэмд ч утга учир, үнэ цэн гэж байдаг. Сэтгэлийн гэмийг сэтгэлийн гэм чигт нь дуусгах уу, сэтгэлийн шим болгон хөгжүүлэх үү гэдэг биднээс шалтгаална гэсэн үг юм.

Энэ жилийн хамгийн эхний өдөр Нотогийн хойгт томоохон хэмжээний газар хөдлөлт болж, багагүй хохирол учруулсан. Бидний хувьд газар хөдлөлт нь байгалийн гамшиг боловч дэлхийн түүхээс харвал газар хөдлөлт нь одоо ч тасралтгүй явагдаж байгаа байгалийн үзэгдлийн нэг юм. Энэ баримтыг байгаагаар нь хүлээн авах нь байгалийн гамшгийг хүн төрөлхтөний билиг оюунтай холбох чухал үе шат гэж хэлж болно. Мэдээж хохирол амссан хүмүүсийн нөхцөл байдлыг хараад юу ч болоогүй юм шиг хүлээн авах боломжгүй. Нас барсан хүмүүсийн хойноос гашуудаж, амьдрал нь хүнд байгаа хүнд санаа тавихгүй бол болохгүй.

Бид үнэнтэй нүүр тулж, хүлээн авч, янз бүрийн сэтгэл хөдлөлдөө автан зовж шаналж байхдаа илүү сайхан амьдрах билиг оюун болон бусдыг бодох энэрэнгүй сэтгэлээ хөгжүүлж байдаг. Үүнийг л насан туршдаа бурханы зам мөрөөр замнах гэж хэлж болно.

«Косей» 2024 оны 4-р сарын дугаараас



Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

Гишүүн болвол

Гишүүн болвол

Буддын шашны гүнгэрвааг Рисшо Косей Кайд Гохоозэн гэж нэрлэдэг. Гишүүн болвол гүнгэрваа дотроо Гол шүтээн (Ялж төгс нөгчсөн дуусашгүй буян үйлдэгч номын хаан Шагжамүни), Үүсгэн байгуулагч, Мёокоо багштаны сахилын нэр (Үүсгэн байгуулагч болон хамтран үүсгэн байгуулагчид зориулан бүтээсэн сахилын нэр), Өвөг дээдсийн сахиус (гишүүдийн өвөг дээдэст зориулан бүтээсэн

өргөл), Газар нутгийг аргадах сахиус (амьдарч буй газрын сүнсэнд зориулсан өргөл)-ыг хүлээн авч, хүндэтгэн залдаг. Энэ үйлийг Бурхан залах ёслол гэж нэрлэдэг.

Уг ёслолын үеэр бурхны үйлийг хийдэг гишүүд цуглан, ном хурж сургаалыг хамтдаа хэрэгжүүлэхээ амладаг.



Чимх мэдлэг

“Намо мёо хоо рэн гэ кёо” бол өдөр тутам чанга дуугаар уншдаг тарни юм. “Намо” гэдэг нь “итгэдэг” гэсэн утгатай ба “Мёо хоо рэнгэ кёо” нь “Цагаан лянхуа судар”-ын албан ёсны нэр болно. Тиймээс энэ тарни нь Цагаан лянхуа судрын сургаалд чин сэтгэлээсээ илгэж хэрэгжүүлдэг гэсэн утгатай юм.

* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



Андудтайгаа хамт (санга)



Нийгэмлэгийн гишүүн айл бүр гүнгэрваандаа залсан Гол шүтээн болон Үүсгэн байгуулагч, Мёоко багштаны сахилын нэр, өвөг дээдэст зориулсан сахиус, газар нутгийг аргадах сахиусандаа чин сэтгэлээсээ залбирч мөргөдөг.

Бурхан багш болон өвөг дээдэстээ сэтгэлээ зориулан цэцэг, ус, цай, будаа зэрэг өргөлийг тахилын ширээнээ өргөдөг билээ.

Мөн өдөр бүрийг талархлаар эхлүүлэн сайн үйл бүтээхийг зорьж, өөрийн үйл хөдлөлийг тунгаан боддог юм. Өглөөдөө алгаа хавсран талархаж, сургуулиасаа хариад өдрийн ололт амжилтаа тайлагнаж байвал бурхан багш, өвөг дээдэс маань талархах билээ.

Уудам тэнгэрийн доор, баяр хөөрийг авчирч
чаддаг хүн байхсан

Акагава Кэйичи

Та бүхний энэ өдрийн амгаланг эрье. Цэцэг навч дэлгэрэх урин хаврын улирал айлчиллаа. 4 сарын 8-нд болох Бурхан багшийн мэндэлсэн өдрийн баяр хаяанд иржээ. Бүгдээрээ Шагжамүни бурхны төрсөн өдрийг ёслол төгөлдөр тэмдэглэцгээе.

Хаврын цаг агаараас шалтгаалан сэтгэл санаа тогтворгүй болов уу, хэдэн өдрийн өмнө би бүтэлгүйтсэн. Ажилдаа явах замдаа оффисын барилгад нэвтэрдэг карт болон ажлын үнэмлэхээ хийсэн чухал кэйсээ гээчихсэн юм. Хаа сайгүй хайсан ч олдсонгүй. Хаана гэсэнээ мэдэхгүй байсан тул олдохгүй байх гэж найдвар алдран бодож байлаа. Бууж өгсөн байсан боловч юутай ч буудлын олсон гэсэн эд зүйлсийн товчоо руу утсаар яриад үзтэл гэсэнээс хойш 4-хөн цаг болж байхад нэгэн сайхан сэтгэлтэй хүн хотын буудлын захиргаанд хүргэж өгсөн байв. Өөрийн хайхрамж болгоомжгүйд харамсаж байсан боловч гэсэн зүйлээ баттай эргэж олдсон гэдгийг мэдэнгүүт нүдний өмнөх зүйлс гэрэл гэгээтэй харагдаж эхлэв.

Огт танихгүй хүний халуун дулаан сэтгэлийн ачаар миний зүрх баяр талархлаар дүүрэн болов. Энэ өчүүхэн гашуун туршлага, надад тусласан хүний адилаар уудам тэнгэрийн доор хүмүүст амар амгалан, баяр хөөрийг авчирдаг хүн байх хүслийг минь хүчтэйгээр мэдрүүлж өглөө.




2024 оны 2 сарын 25-ны өдөр. Тайпэй сүмийн гишүүдийн хамт (Урд эгнээний голд Акагава хэлтсийн дарга)

Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers



facebook



twitter



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp